# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Рашаант сумын Соёлын төвийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2025/018/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран
Утас: 99389927 Цахим хаяг: MandakhnaranL@audit.gov.mn

Гурван Хөх Морьт Аудит ХХК
Гүйцэтгэх захирал: Н.Отгончимэг
Утас: 99051815 Цахим хаяг: gurvankhukhmoritllc@gmail.com
Аудитор: Ш.Саранчимэг
Утас: 99834361 Цахим хаяг: gurvankhukhmoritllc@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХӨВСГӨЛ АЙМГИЙН РАШААНТ
СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН ДАРГА
Л.БАЯРЦЭНГЭЛ ТАНАА

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/286

танай ____________-ны № ____________-т

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Рашаант сумын Соёлын төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Хөвсгөл аймгийн Рашаант сумын соёлын төв нь сумын Засаг даргын тамгын газартай “Орон нутгийн өмчийн барилга, ажлын байр түрээслүүлэн ашиглуулах гэрээ”-г нэг жилийн хугацаатай байгуулан 14,140.0 мянган төгрөгийн орлогыг хүлээн авсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналтын горим сорил хэрэгжүүлэхэд зөрчилтэй асуудал илрээгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Тус төвийн дарга нь Хөвсгөл аймгийн Рашаант сумын засаг даргатай 2024 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтийг 93.0 хувьтай биелүүлж ажилласан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **38,884,795.99** | **52,345,840.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **9,487,625.99** | **-** |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 9,487,625.99 | - |
| 3121 | Төгрөг | 9,487,625.99 | - |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 9,487,625.99 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **29,397,170.00** | **52,345,840.00** |
| 354 | Хангамжийн материал | 29,397,170.00 | 52,345,840.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 81,100.00 | 661,450.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 29,316,070.00 | 51,684,390.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,471,558,325.24** | **1,457,316,770.71** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,471,558,325.24** | **1,457,316,770.71** |
| **392** | **Биет хөрөнгө** | **1,464,886,492.03** | **1,450,954,937.58** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,455,000,000.00 | 1,455,000,000.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (150,815,972.06) | (175,607,638.70) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | - | 29,700,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | - | (29,700,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 88,646,594.78 | 101,311,894.78 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (19,330,366.61) | (19,465,962.20) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 72,244,355.00 | 56,301,679.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (25,953,496.08) | (12,750,412.30) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 18,685,000.00 | 18,685,000.00 |
| 39217 | Ном | 26,410,377.00 | 27,480,377.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **6,671,833.21** | **6,361,833.13** |
| 39301 | Программ хангамж | 1,600,000.00 | 1,600,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (364,166.79) | (674,166.87) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 5,436,000.00 | 5,436,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,510,443,121.23** | **1,509,662,610.71** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **37,195,253.00** | **11,751,133.03** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **37,195,253.00** | **11,751,133.03** |
| 413 | Өглөг | 37,195,253.00 | 11,751,133.03 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 37,195,253.00 | 11,751,133.03 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,473,247,868.23** | **1,497,911,477.68** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,473,247,868.23 | 1,497,911,477.68 |
| **511** | **Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан** | **33,538,170.00** | **33,538,170.00** |
| **51101** | **Өмч: - төрийн** | **33,538,170.00** | **33,538,170.00** |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 1,439,709,698.23 | 1,464,373,307.68 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,277,767,743.56 | 1,448,181,960.23 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 161,941,954.67 | 16,191,347.45 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,510,443,121.23** | **1,509,662,610.71** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **405,681,264.33** | **350,434,490.96** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **154,265,050.00** | **40,581,364.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **154,265,050.00** | **40,581,364.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 154,265,050.00 | 21,393,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 18,411,200.00 | 20,393,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 650,000.00 | 1,000,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 135,203,850.00 | 19,188,364.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **251,416,214.33** | **309,853,126.96** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 132,798,514.33 | 204,631,526.96 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 132,798,514.33 | 204,631,526.96 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 118,617,700.00 | 105,221,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 118,617,700.00 | 105,221,600.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **243,739,309.66** | **334,243,143.51** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **243,739,309.66** | **334,243,143.51** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **228,630,359.66** | **315,282,976.38** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **90,987,967.38** | **139,549,811.09** |
| 210101 | Үндсэн цалин | 62,797,880.22 | 90,039,380.31 |
| 210102 | Нэмэгдэл | 16,134,742.93 | 35,937,991.18 |
| 210104 | Урамшуулал | 12,055,344.23 | 13,572,439.60 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **11,384,328.28** | **17,514,130.73** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 7,753,017.42 | 12,060,321.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 912,107.13 | 1,310,292.85 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 729,666.30 | 673,422.44 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 165,326.28 | 632,342.44 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,824,211.15 | 2,837,752.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **67,900,633.00** | **78,249,742.03** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,700,000.00 | 2,410,650.83 |
| 210302 | Түлш, халаалт | 63,200,633.00 | 75,839,091.20 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **15,632,472.68** | **7,544,650.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 316,700.00 | 2,019,650.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,523,150.00 | 2,500,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 500,322.68 | 1,214,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 50,000.00 | 500,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,608,700.00 | 1,310,300.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 11,633,600.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | **-** | **148,800.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 148,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **-** | **4,440,000.00** |
| 210604 | Урсгал засвар | - | 4,440,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **156,000.00** | **1,296,500.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 156,000.00 | 1,296,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **5,793,544.00** | **18,465,944.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,258,600.00 | 16,661,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 150,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 510,000.00 | 1,630,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 24,944.00 | 24,944.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **36,775,414.32** | **48,073,398.53** |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 740,000.00 | 4,385,580.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 36,035,414.32 | 43,687,818.53 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **15,108,950.00** | **18,960,167.13** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **15,108,950.00** | **4,630,500.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 500,000.00 | 3,850,500.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 13,893,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 715,950.00 | 780,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 14,329,667.13 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 14,329,667.13 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **161,941,954.67** | **16,191,347.45** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **161,941,954.67** | **16,191,347.45** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**/Төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **C01** | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **33,538,170.00** | **1,277,767,743.56** | **1,311,305,913.56** |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 33,538,170.00 | 1,277,767,743.56 | 1,311,305,913.56 |
| C07 | **Тайлант үеийн үр дүн** | **0.00** | **161,941,954.67** | **161,941,954.67** |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **33,538,170.00** | **1,439,709,698.23** | **1,473,247,868.23** |
| D01 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 33,538,170.00 | 1,439,709,698.23 | 1,473,247,868.23 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 8,472,262.00 | 8,472,262.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 33,538,170.00 | 1,448,181,960.23 | 1,481,720,130.23 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 16,191,347.45 | 16,191,347.45 |
| **D09** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **33,538,170.00** | **1,464,373,307.68** | **1,497,911,477.68** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**/Төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **270,477,414.33** | **331,246,126.96** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **19,061,200.00** | **21,393,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **19,061,200.00** | **21,393,000.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 19,061,200.00 | 21,393,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 18,411,200.00 | 20,393,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 650,000.00 | 1,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **251,416,214.33** | **309,853,126.96** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 132,798,514.33 | 204,631,526.96 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 132,798,514.33 | 204,631,526.96 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 118,617,700.00 | 105,221,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 118,617,700.00 | 105,221,600.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **249,163,962.34** | **330,475,852.95** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **249,163,962.34** | **330,475,852.95** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **233,565,712.34** | **311,515,685.82** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **90,987,967.38** | **139,549,811.09** |
| 210101 | Үндсэн цалин | 62,797,880.22 | 90,039,380.31 |
| 210102 | Нэмэгдэл | 16,134,742.93 | 35,937,991.18 |
| 210104 | Урамшуулал | 12,055,344.23 | 13,572,439.60 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **11,384,328.28** | **17,514,130.73** |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 7,753,017.42 | 12,060,321.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 912,107.13 | 1,310,292.85 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 729,666.30 | 673,422.44 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 165,326.28 | 632,342.44 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,824,211.15 | 2,837,752.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **118,617,700.00** | **95,221,600.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,700,000.00 | 2,410,650.83 |
| 210302 | Түлш, халаалт | 113,917,700.00 | 92,810,949.17 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **4,636,172.68** | **8,914,100.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 300,000.00 | 2,600,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,523,150.00 | 2,500,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 500,322.68 | 1,214,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 50,000.00 | 500,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,162,700.00 | 2,099,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **-** | **500,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **810,000.00** | **18,530,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 810,000.00 | 8,530,000.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 10,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **156,000.00** | **1,296,500.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 156,000.00 | 1,296,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **5,923,544.00** | **20,765,944.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,388,600.00 | 18,961,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 150,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 510,000.00 | 1,630,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 24,944.00 | 24,944.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,150,000.00** | **9,223,600.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,150,000.00 | 9,223,600.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **15,598,250.00** | **18,960,167.13** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **15,598,250.00** | **4,630,500.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 989,300.00 | 3,850,500.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 13,893,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 715,950.00 | 780,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | **14,329,667.13** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 14,329,667.13 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **21,313,451.99** | **770,274.01** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **11,827,900.00** | **10,257,900.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **11,827,900.00** | **10,257,900.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **11,827,900.00** | **10,257,900.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 11,827,900.00 | 10,257,900.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(11,827,900.00)** | **(10,257,900.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **9,485,551.99** | **(9,487,625.99)** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **2,074.00** | **9,487,625.99** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **9,487,625.99** | **-** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/Төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **224,804,600.00** | **221,182,485.82** | **3,622,114.18** | **98.30%** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **224,804,600.00** | **221,182,485.82** | **3,622,114.18** | **98.30%** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **220,174,100.00** | **216,551,985.82** | **3,622,114.18** | **98.89%** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **141,886,400.00** | **139,549,811.09** | **2,336,588.91** | **98.35%** |
| 210101 | Үндсэн цалин | 83,276,100.00 | 90,039,380.31 | (6,763,280.31) | 108.1% |
| 210102 | Нэмэгдэл | 45,133,500.00 | 35,937,991.18 | 9,195,508.82 | 79.63% |
| 210104 | Урамшуулал | 13,476,800.00 | 13,572,439.60 | (95,639.60) | 100.7% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **17,735,700.00** | **17,514,130.73** | **221,569.27** | **98.75%** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 12,060,300.00 | 12,060,321.00 | (21.00) | 100.0% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,418,800.00 | 1,310,292.85 | 108,507.15 | 92.35% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 709,400.00 | 673,422.44 | 35,977.56 | 94.93% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 709,400.00 | 632,342.44 | 77,057.56 | 89.14% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,837,800.00 | 2,837,752.00 | 48.00 | 100.00% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **10,199,400.00** | **9,914,100.00** | **285,300.00** | **97.20%** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,600,000.00 | 2,600,000.00 | - | 100.0% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,500,000.00 | 2,500,000.00 | - | 100.0% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,500,000.00 | 1,214,300.00 | 285,700.00 | 80.95% |
| 210404 | Ном, хэвлэл | 1,000,000.00 | 1,000,000.00 | - | 100.0% |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 500,000.00 | 500,400.00 | (400.00) | 100.1% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,099,400.00 | 2,099,400.00 | - | 100.0% |
| **2105** | **Нормативт зардал** | **500,000.00** | **500,000.00** | **-** | **100.0%** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 500,000.00 | 500,000.00 | - | 100.0% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **15,267,900.00** | **15,267,900.00** | **-** | **100.0%** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 15,267,900.00 | 15,267,900.00 | - | 100.0% |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,300,000.00** | **1,296,500.00** | **3,500.00** | **99.73%** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,300,000.00 | 1,296,500.00 | 3,500.00 | 99.73% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **21,571,100.00** | **20,835,944.00** | **735,156.00** | **96.59%** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 19,061,100.00 | 19,031,000.00 | 30,100.00 | 99.84% |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 150,000.00 | 150,000.00 | - | 100.0% |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,320,000.00 | 1,630,000.00 | 690,000.00 | 70.26% |
| 210807 | Газрын төлбөр | 40,000.00 | 24,944.00 | 15,056.00 | 62.36% |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **11,713,600.00** | **11,673,600.00** | **40,000.00** | **99.66%** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,713,600.00 | 11,673,600.00 | 40,000.00 | 99.66% |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **4,630,500.00** | **4,630,500.00** | **-** | **100.0%** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **4,630,500.00** | **4,630,500.00** | **-** | **100.0%** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 3,850,500.00 | 3,850,500.00 | - | 100.0% |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 780,000.00 | 780,000.00 | - | 100.0% |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **330,246,200.00** | **327,404,158.82** | **3,842,041.14** | **98.91%** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **204,631,600.00** | **201,009,558.86** | **3,622,041.14** | **98.23%** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 204,631,600.00 | 201,009,558.86 | 3,622,041.14 | 98.23% |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **20,173,000.00** | **21,393,000.00** | **1,220,000.00** | **105.2%** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 20,173,000.00 | 21,393,000.00 | 1,220,000.00 | 105.2% |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **1** | **1** | - | **100.0%** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** | - | **100.0%** |
| **610001** | Төсвийн байгууллага | 1 | 1 | - | 100.0% |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **6** | **6** | - | **100.0%** |
| **620001** | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0% |
| **620002** | Гүйцэтгэх ажилтан | 4 | 4 | - | 100.0% |
| **620003** | Үйлчлэх ажилтан | 1 | 1 | - | 100.0% |

## 2.6 Аудит хийсэн орон нутгийн санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/Төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **105,221,600.00** | **105,221,600.00** | **-** | **100.0%** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **105,221,600.00** | **105,221,600.00** | **-** | **100.0%** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **105,221,600.00** | **105,221,600.00** | **-** | **100.0%** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **95,221,600.00** | **95,221,600.00** | **-** | **100.0%** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,299,700.00 | 2,410,650.83 | 889,049.17 | 73.06% |
| 210302 | Түлш, халаалт | 91,921,900.00 | 92,810,949.17 | (889,049.17) | 100.9% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 10,000,000.00 | 10,000,000.00 | **-** | **100.0%** |
| 210604 | Урсгал засвар | 10,000,000.00 | 10,000,000.00 | | 100.0% |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **105,221,600.00** | **105,221,600.00** | **-** | **100.0%** |
| 32 | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **105,221,600.00** | **105,221,600.00** | - | 100.0% |
| **320001** | Орон нутгийн төсвөөс | **105,221,600.00** | **105,221,600.00** | - | 100.0% |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

**Тус байгууллага нь үндсэн үйл ажиллагааны хүрээнд жил бүр нэмэлт орлого олдог хэдий ч орлогыг санхүүжилтийн эх үүсвэр болгон төлөвлөж өөрийн орлогын төлөвлөгөөг батлуулахгүйгээр шууд зарцуулж байгаад анхаарал хандуулах шаардлагатай гэж үзлээ.**

## 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6,454.3 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлэв.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага хариуцлага тооцох санал хүргүүлээгүй.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав.

#### 5.3.1 Өр төлбөрийн данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* 2024 оны жилийн эцсийн байдлаар 11,751.1 мянган төгрөгийн түлш халаалтын өглөгтэй байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна. Мөн "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг баримтлан ажиллах;

#### 5.3.2 Түрээсийн орлогын бүртгэлтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Түрээсийн орлогын 30 хувь 4,003.8 мянган төгрөгийг төрийн сангийн дансанд төвлөрүүлээгүй ба тайлант хугацаанд өглөгөөр бүртгээгүй байна. Энэ нь Орон нутгийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журмын 2.5.Орон нутгийн өмчийг түрээсээр эзэмшүүлэгч хуулийн этгээд нь орон нутгийн өмчийг түрээсээр эзэмшүүлж олсон орлогын 70 хувийг Байгууллагын өөрийн орлогод төвлөрүүлж, барилга байгууламжийн засвар, үндсэн хөрөнгө худалдан авах зардалд зарцуулж болно. Тус орлогын 30 хувийг Төрийн сангийн Хөрөнгө борлуулсны орлогын дансанд сар тутам төвлөрүүлнэ. Орлогын зарцуулалт, төвлөрүүлэлтийн мэдээг улирал болгоны сүүлийн сарын 25-ны дотор Орон нутгийн өмчийн газарт гаргаж өгнө гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна. Мөн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Орон нутгийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журмын 2.5.Орон нутгийн өмчийг түрээсээр эзэмшүүлэгч хуулийн этгээд нь орон нутгийн өмчийг түрээсээр эзэмшүүлж олсон орлогын 30 хувийг Төрийн сангийн Хөрөнгө борлуулсны орлогын дансанд сар тутам төвлөрүүлнэ. Орлогын зарцуулалт, төвлөрүүлэлтийн мэдээг улирал болгоны сүүлийн сарын 25-ны дотор Орон нутгийн өмчийн газарт гаргаж өгнө гэж заасныг мөрдөж ажиллах;

#### 5.3.3 Хуулийн хэрэгжилтийг хангах асуудал

*Илрүүлэлт:* Албан хаагчдад олгосон 2,450.5 мянган төгрөгийн түлээний хөнгөлөлтөөс суутгал аваагүй татвар, нийгмийн даатгалын тайланд тайлагнаагүй байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ноогдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй мөн "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Суутган төлөгчийн үүргээ биелүүлж ажиллах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 11,751.1 мянган төгрөгийн түлш халаалтын өглөгтэй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| Түрээсийн орлогоос 30 хувийг төвлөрүүлэх | 1 | 4,003.8 | | | | | 1 | 4,003.8 |
| хөнгөлөлтөөс суутгал аваагүй татвар, НД-ын тайланд тайлагнаагүй. | 1 | 2,450.5 | | | | | 1 | 2,450.5 |
| **Дүн** | **3** | **6,454.3** | | | | | **3** | **6,454.3** |